



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 21/315

Хэрлэн сум


Нөхөн олговорт хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн тээврийн газраас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу аймгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2023 онд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчсоны нөхөн олговорт 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг “Засаг дарга данс” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ